

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
6/21/2017

2017 оны хагас жил

ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр, сая төгрөг)	Хэрэгжилтийн хувь	
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	%
1	2	3	4	5	6	7	8	9
Тэргүүлэх зорилт №1. Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.								
1.24. “Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	1	Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах төслийг боловсруулж, хэрэгжүүлэх	2017	УУХҮЯ		-	Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллахаар шалгарсан хөрөнгө оруулагчтай хийх гэрээний нөхцлийг сайжруулах чиглэлээр хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгийн ахлагчаар УУХҮ-ийн сайд ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд ордыг иж бүрэн ашиглах ажлыг эрчимжүүлэх зорилгоор харьцуулсан судалгаа хийж, санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны А/67-р тушаалаар байгуулан Эрдэнэс Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК -ийн төлөөллийг оролцуулан, орд ашиглах харьцуулсан тооцоо, судалгааг хийж ордыг иж бүрэн ашиглах боломжит хувилбарыг боловсруулан ажлын хэсгийн ахлагч /Сайд/-д урьдчилсан байдлаар танилцуулаад байна. Мөн Энержи Ресурс компанийн Ухаа Худаг уурхайн 0-р давхаргын нүүрстэй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Цанхийн баруун хэсгийн 3, 4, 0-р давхаргын чанар муутай нүүрсийг хольж баяжуулан үр дүнг тодорхойлох үүргийг УУХҮ-ийн сайдаас Эрдэнэс Таван Толгой болон Энержи Ресурс компаниудад өгсний дагуу тус компаниуд анхдагч хэлэлцээрийг эхлүүлээд байна. Уул уурхайн яам /хуучнаар/, Япон Улсын Шинэ эрчим хүч, аж үйлдвэрийн технологийн хөгжлийн байгууллага /NEDO/ хооронд 2016 оны 02 дугаар сард “Нүүрсний хуурай баяжуулалтын технологийг Монголд нутагшуулахад хамтран ажиллах талаар Харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулсан ба тус санамж бичгийн хүрээнд Тавантолгойн ордод түшиглэн жилд 300 мян.тн нүүрсийг хуурай аргаар баяжуулах хүчин чадалтай загвар үйлдвэрийг байгуулах “Гүйцэтгэлийн гэрээ”-г Япон Улсын Нагата инженеринг болон Монголын “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хооронд байгуулж, холбогдох туршилт судалгааны, ажлыг хийж гүйцэтгэхээр тохиролцсон боловч 2017 оны 4-р сараас “Эрдэнэс Монгол” ХХК нь санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас уг төслийг хэрэгжүүлэх боломжгүйгээ илэрхийлсэн тул УУХҮЯ-наас “Энержи Ресурс” ХХК-д 2017 оны 5 дугаар сард санал тавьсны дагуу “Энержи Ресурс” ХХК төслийг судлан үзэж, хамтран хэрэгжүүлэх боломжтой талаар саналаа илэрхийлсэн тул Санамж бичигт дурьдсан төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын нэр болон, ажлын графикийг өөрчлөх, төслийг хэрэгжүүлэх Нагата инженеринг компани болон “Энержи Ресурс” ХХК хооронд гүйцэтгэлийн гэрээг байгуулахаар холбогдох ажлууд хийгдэж байна. - “Таван толгойн ордыг иж бүрэн ашиглах ажлыг эрчимжүүлэх тухай” ЗГ-ын тогтоолын төслийн боловсруулж холбогдох байгууллага, яамдаас санал авахаар хүргүүлээд байна.	40

	2	Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	2016-2020	УУХҮЯ	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 9,600,000	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд далд уурхайн босоо амны малталтууд, хөндлөн нэвтрэлтүүд, туслах дэд бүтцийн ажлууд ахицтай үргэлжилж байгаа бөгөөд газрын гадарга руу гарах конвейерын налуу амын хос налуу малталт тус бүр 56 метр, 64 метрийн гүнд хүрээд байна. Далд уурхайн 2 дугаар босоо аманд 1284 метр нэвтрэлт хийхээс 1209 метр, 5 дугаар босоо аманд 1178 метр нэвтрэлт хийхээс 500 гаруй метрийн босоо нэвтрэлт хийгээд байна. Налуу нэвтрэлтийн ам нийт 6.7 км байх бөгөөд үүнээс тузан дамжуургын ам 91 метрт, үйлчилгээний налуу ам 98 метрт хүрээд байна. Төслийн нийт капитал хөрөнгө оруулалтын төсөв 5.34 тэрбум ам доллар бөгөөд нийт тендер зарласан ажлын гэрээний үнийн дүн 1.32 тэрбум ам. долларт хүрсэн байна.	70
					Далд уурхайн ажлын гүйцэтгэл 25 хувь		
	3	Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх	2016-2020	УУХҮЯ	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1,300,000	Тус төслийг хэрэгжүүлэхэд 600 сая ам.доллар шаардлагатай байгаа бөгөөд уг санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Үндэсний хөгжлийн газраас боловсруулсан "Монгол Улсын 2018-2021" оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд тусгуулаад байна. Мөн "Цагаан суваргын ордыг түшиглэн катодын зэсийн үйлдвэр байгуулах" төслийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж хийх шинжээчдийн хэсгийг УУХҮС-ын 2016 оны 11 сарын А/62 дугаар тушаалаар байгуулан шинжээчдийн нэгдсэн дүгнэлтийг нэгтгэн гаргаж, төсөл боловсруулагч, хэрэгжүүлэгчид хүргүүлэн холбогдох засварыг хийлгэн Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.	40
					Санхүүжилт бүрэн хийгдэх		
Тэргүүлэх зорилт №2.1. Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна.							
2.11. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.	3	Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	2017-2020	БХБЯ	Чөлөөт бүсийн хот төлөвлөлтийн баримт бичигтэй болох, дэд бүтцийн 2 дугаар ээлжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх	2017 оны 05 сарын 12-15-ны өдрүүдэд БНХАУ-д зохион баяуулагдсан "Бүс ба Зам" уулзалтанд МУ-ын ерөнхий сайд оролцохтой холбогдуулан айлчлалын удирдамж, хэлэлцээрийн сэдэвт тусгуулах саналыг ГХЯ-нд хүргүүлсэн. Мөн Талын зам болон "Бүс ба Зам" санаачлагыг уялдуулах тухай Засгийн газар хоорондын санамж бичгийн төсөлд ГХЯ-д 2017.05.02-ны өдрийн 01/1307 тоот, 2017.05.25-ны өдрийн 02/1577 тоот албан бичгээр тус тус санал өгсөн.	40
2.17. Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.	1	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулах	2017-2018	УУХҮЯ	- Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, хуульд өөрчлөлт оруулах	УУХҮС-ын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн тушаалаар "Газрын тосны бүтээгдэхүүний тухай" хуулийг шинэчлэн найруулах, төслийг боловсруулах, хянах, эцэслэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг, АМГТГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн а/45-р тушаалаар хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, холбогдох тооцоо судалгааг хийх, төслийг боловсруулах үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг хамруулсан өргөн бүрэлдэхүүнтэй дэд ажлын хэсгийг тус тус байгуулан хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж байна.	40

3	Алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих бодлогыг баримтлах	2016-2020	УУХҮЯ		Газрын тосны бүтээгдэхүүний хил үнэ, валютын ханшийн өөрчлөлт болон бусад холбогдох зардалтай уялдуулан шатахууны жижиглэн борлуулж буй үнийн зохицуулалтыг хийх, мөн тээвэр ложистикийн зардал, тухайн бүс нутгийн хилийн боомтоор газрын тосны бүтээгдэхүүн импортлох боломжийг судлах	"Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 15 дугаар тогтоолоор шинэчлэн байгуулав. Зөвлөлийн хуралдааныг нийт 3 удаа зохион байгуулж холбогдох зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлж ажиллав. Үүний дүнд Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 109 дүгээр, 11 дүгээр сарын 30-ны өдрийн 166 дугаар, 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр тогтоолуудаар тус тус автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг тодорхой хэмжээгээр бууруулан, шатахууны жижиглэнгийн үнийг өсгөхгүй, тогтвортой байлгах арга хэмжээг аваад байна. Өнөөгийн байдлаар импортын автобензин, дизелийн түлшинд ногдох онцгой албан татварын хэмжээ төвийн бүсэд 30,000-70,000 төгрөг, зүүн болон баруун бүсийн боомтуудад тэг /0/ төгрөгөөр тогтоогоод байна. Улсын хэмжээнд шатахууны жижиглэнгийн үнэ 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Аи-92 автобензин 30 орчим төгрөг, дизелийн түлш 60 орчим төгрөгийн тус тус зөрүүтэй байна.	70
6	Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах	2016-2020	УУХҮЯ		Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх	Улаанбаатар хот болон томоохон суурин газруудад бензин, түлшний чанарын шаардлагыг Евро-5 стандартад шилжүүлэх ажлын хүрээнд Үндэсний стандартын төсөл боловсруулан Стандартчиллын Үндэсний хорооны 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав. Мөн АНУ-ын NFPA-58 стандарт, дүрмийн орчуулгад үндэслэн Монгол орны онцлогт тохирсон Үндэсний стандартын төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. "Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлын норм", "Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлыг тооцоолох аргачлал"-ын төслийг боловсруулж "Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлын норм"-ыг Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний 03 дугаар тогтоолоор батлуулсан ба "Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлыг тооцоолох аргачлал"-ыг сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. Шатахууны чанарын хяналтын тогтолцоог Ашигт малтмал, газрын тосны газар болон БНСУ-ын Газрын тосны бүтээгдэхүүний чанар, хангамжийн газар /К-Петро/ хооронд 2017.04.19-ний өдөр "Техникийн Хамтын Ажиллагааны Харилцан Ойлголцлын САНАМЖ БИЧИГ" байгуулж судалгааны ажлыг эхлүүлээд байна.	70
7	Гашуун сухайт, Ханх, Хавирга зэрэг боомтуудаар бүтээгдэхүүн тогтмол импортлох ажлыг эхлүүлэх, улмаар тээвэр ложистикийн зардлыг бууруулах, өртгийг багасгах судалгаа хийх	2016-2020	УУХҮЯ		Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх	МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын XIV хуралдааны үеэр Монгол талаас Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга зэрэг боомтуудаар шатахуун импортлох хүсэлтийг Хятадын талд тавьсан ба талауд судалж үзэхээр тохиролцсон. Гаалийн ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь төлөөлөгч болон Буряд улсын гаалийн газрын төлөөлөгчдийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ний өдөр "Ханх" боомт дээр хийсэн уулзалтаар тус боомтоор газрын тосны бүтээгдэхүүн импортлох боломжийн талаар санал солилцож уг асуудлаар УУХҮЯ нь бодлогын хүрээнд дэмжиж ажиллах талаар Улаан-Үүдийн консулын газарт мэдэгдсэн. БНХАУ-ын Чайна Ойл компанийн төлөөлөлтэй газрын тосны бүтээгдэхүүний үнэ, хангамж, боомтуудын талаар уулзалт, хэлэлцээрийг 2017 оны 03 дугаар сард зохион байгуулав. Уулзалтаар Замын-үүдээс бусад боомтуудаар бүтээгдэхүүн импортлох боломжийн талаар санал тавьсан бөгөөд Бургастай болон бусад боомтуудаар шатахуун нийлүүлэх ажлыг ойрын хугацаанд хамтран судлаж эхлүүлэхээр тохиролцов. Үүний дагуу АМГТГ нь холбогдох тооцоо судалгааг хийж байна.	70

Тэргүүлэх зорилт №2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.

2.48. Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.	6	"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг боловсруулан батлуулах	2016-2020	ХХААХҮЯ	Өнөөгийн байдлын судалгаа хийж, аж үйлдвэрийн зураглал гаргах, хөтөлбөрийн төслийг боловсруулж батлуулах	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/157 дугаар тушаалаар байгуулагдсан "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр"-ийг боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллав. Ажлын хэсгээс Монгол Улсад хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн танилцуулгыг боловсруулан Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын хуралдааны 2016 оны 60 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах тухай санал гарсны дагуу ажлын хэсэг "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийг боловсруулж, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлэн болгосон байна. Энэхүү ажлын хүрээнд Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл болон салбарын эрдэмтэн, доктор, ААН-үүдийн удирдлагуудтай 21:100 хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэх ажлыг УУХҮЯ-нд 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. Хүнд үйлдвэрийн зөвлөлөөс 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 17/47 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг Ажлын хэсэгт хүргүүлэв. ХХААХҮЯ-ны 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1470 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийн төсөлд санал боловсруулж, 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/1159 тоотой хариу хүргүүлэв.	70
	7	"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	2016-2020	ХХААХҮЯ	Улсын төсөв, гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 301,000 Нөхцөл байдлын судалгаанд үндэслэн үйлдвэржилтийн зураглал гаргаж, аймаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурласан үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулах	Хөтөлбөр батлагдсаны дараа дүрэм, журам гарна. Хугацаа болоогүй.	/-/

Тэргүүлэх зорилт №2.3. Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

2.59. Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн	1	Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулах	2016-2020	УУХҮЯ	Батлагдсан - 4723.7 Гүйцэтгэл - 1384.4 Санхүүжилт - 1314.8	Улсын төсөв 30,700.0	2017 оны хагас жилийн байдлаар Монгол Алтай-50, Ар чулуут-50, Хайрхан уул-50, Дөрөө нуур-50, Булган-50, Буурал хайрхан-50, Тойромын хөндий-50, Хөх нуур-50, Тахилт-50, Эргэлийн зоо-50 төслүүдийн үр дүнг ЭБМЗ-өөр хэлэлцэн хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 36.7%-ийг хамруулсан. Тайлант онд суурин болон хээрийн судалгааны ажилтай 27 төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Шинээр 6 төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд шинэ 6 төслийн талбай нутаг дэвсгэрийн 1.4%-д хийгдэнэ.	40
						Нутаг дэвсгэрийн 41 хувийг хамруулж, геологийн тогтоц, ашигт малтмалын хэтийн төлвийн үнэлгээг өгөх		

салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.

салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.	2	Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг нэгтгэх	2017-2020	УУХҮЯ	Батлагдсан - 502.3 Гүйцэтгэл - 160.6 Санхүүжилт - 160.6	Улсын төсөв 3,900.0	Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлаар нутаг дэвсгэрийн 90%-ийг бүрэн хамруулсан бөгөөд 2017 оны хагас жилийн байдлаар УГЗ-200-Төв Монгол-VI төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцэн хүлээн авсан. Дорнод Монгол-VI, Дорнод Монгол-VII, Төв Монгол-V төслүүдийн үр дүнгийн тайланг тайлант оны эцсээр хүлээн авна. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлын 2017 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/96 дугаар тушаалаар батлуулан хээрийн судалгааг эхлүүлээд байна.	40
	3	Монгол Улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх	2016-2020	УУХҮЯ	Батлагдсан - 2694.9 Гүйцэтгэл - 846.3 Санхүүжилт - 826.5	Улсын төсөв 5,700.0	Агаарын геофизикийн Алтай-1, Алтай-2, Ховд-1 төслүүдийн 2017 оны ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/96 дугаар тушаалаар батлуулж хээрийн болон суурин судалгааны ажлыг хэрэгжүүлж байна. Алтай-1, Алтай-2 төслүүдийн үр дүнгийн тайланг 2017 оны жилийн эцэст ЭБМЗ-өөр хэлэлцүүлснээр нутаг дэвсгэрийн 13% хамрагдана.	40
	4	Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан геохимийн судалгаа хийх	2017-2020	УУХҮЯ	-	Улсын төсөв 2,100.0	Монгол орны нутаг дэвсгэрийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулах зорилгоор төслийг 2018 оноос хэрэгжүүлэх төсөв, төлөвлөгөөг боловсруулан МУ-ын нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулах саналыг СЯ-нд хүргүүлсэн.	40
	5	Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон томоохон хот суурин газрын геоэкологийн болон гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх	2017-2020	УУХҮЯ, БОАЖЯ	Батлагдсан - 275.6	Улсын төсөв 1,100.0	Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологийн нөхцлийг нарийвчилан үнэлэх сэдэвчилсэн судалгааны ажлыг 2017 онд эхлүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/96 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮЯ-ны ТНБД-ын шийдвэрээр тус тус батлуулсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж байна.	40
	6	Эрдэс баялгийн хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан сэдэвчилсэн судалгааны төсөл хэрэгжүүлэх	2017-2020	УУХҮЯ	2. Батлагдсан - 30.8 Гүйцэтгэл - 15.9 Санхүүжилт - 15.9 3. Батлагдсан - 603.5 Гүйцэтгэл - 215.8 Санхүүжилт - 177.3 4. Батлагдсан - 1714.8 5. Батлагдсан - 580.0	14,900.0	1. Монгол орны газрын ховор элементийн металлогени, түүний хэтийн төлвийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн УУХҮС-ын А/58 дугаар тушаалаар хүлээн авсан. 2. Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай аймгуудын нутгийн хэмжээнд Баруун Монголын цул сульфид-2013 төслийг хэрэгжүүлж үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. Үр дүнг 3-р улиралд хүлээн авна. 3. Сансрын зургийн тайлалт-2013, Монгол орны металлогени-2014 төслүүдийн 2017 оны ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/96 дугаар тушаалаар батлуулсан. Төслүүдийн тайлант оны ажлын хэмжээ, арга аргачлал, төсөвт тодотгол хийж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Төслүүдийн үр дүнг жилийн эцэст хүлээн авна. 4. Бүс нутгийн хөгжлийг хангах геологийн судалгааны ажлыг 2017 оноос хэрэгжүүлж эхлэхээр төсөв, төлөвлөгөө, геологийн даалгаврыг боловсруулан батлуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа явагдаж байна. 5. Налайх нүүрсний ордын геологийн тогтоц, нөөцийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор геофизикийн чичирхийллийн судалгааны ажлыг 2017 онд төлөвлөн төсөв, төлөвлөгөө, геологийн даалгаврыг боловсруулан батлуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа явагдаж байна.	40

	7	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул судалгаа, ашиглалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2016-2017	УУХҮЯ	Монгол Улсын эзэмших хувь хэмжээ, нөөц ашигласны төлбөрийн хэмжээг оновчтой зохицуулах эрх зүйн орчин бүрдэх, орд ашиглах гэрээ, хувьцаа эзэмших гэрээ, хамтарсан компани байгуулах гэрээний загвар зөвлөмж гарах	Уул уурхайн, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/51 тоот тушаалаар "Монгол Улсын хэмжээнд цацраг идэвхт ашигт малтмал эрэх хайх, олборлох, боловсруулах үйл ажиллагааны өнөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх асуудлаар санал боловсруулж ажлах үүрэг бүхий" Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд энэхүү ажлын хэсэгт холбогдох байгууллагууд орж ажиллан "Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн талаар санал дүгнэлт боловсруулж ажилласан. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг шинээр батлагдсан "Хууль тогтоомжийн тухай" хуулийн дагуу дахин боловсруулахаар ажиллаж байна.	40
	8	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг төлөвлөх	2016-2020	АМГТГ	Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг шинэ талбайд эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах	Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг шинэ талбайд эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	40
	9	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулах	2016-2020	УУХҮЯ, АМГТГ, ЦЭКАА	Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг гүйцэтгэх, стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах	"Арева майнс" ХХК, "Гурван сайхан" ХХК-д цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, "Орд ашиглах гэрээ"-г байгуулав. Эдгээр компаниудын хувьцааны Монголын Засгийн газарт ноогдох хувь эзэмшлийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. "Арева майнс" ХХК-ийн ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэхээр Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	40
	10	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул, геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх	2016-2020	АМГТГ, ЦЭКАА	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 80,000.0 Одоогийн цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн судалгаа, геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэх	Цөмийн Энергийн Комиссын Ажлын албанд "Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын дагуу хагас жил тутам танилцуулах тойм мэдээний хүрээнд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нөөц, үнэ, зах зээлийн судалгааг гарган хүргүүлж байна. Цөмийн Энергийн комиссын тогтоолын төслийг дэмжиж байгаа талаар 1/3699 тоот албан бичиг хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд Цөмийн Энергийн салбар дахь Монгол-Энэтхэгийн хамтарсан ажлын хэсгийн 3-р хуралдаанд оролцсон.	/-/
2.60. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.	1	Үндэсний геологийн алба байгуулахдаа хууль, эрх зүй, эдийн засгийн үр өгөөж, гадаад улсуудын ижил төстэй байгууллагуудын талаар иж бүрэн судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулж, ЗГ, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэр	2017-2020	УУХҮЯ	- Хууль, эрх зүй, эдийн засгийн үр өгөөж, гадаад улсуудын судалгааг хийж, санал дүгнэлт гаргах	Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд АМЭП төсөлтэй хамтран гадаад орнуудын геологийн албадын судалгаа, хууль эрхзүйн орчны судалгаанд тулгуурлан Үндэсний геологийн алба байгуулах багийг байгуулан ажиллаж байна. Хүний нөөц, үндсэн хөрөнгийн судалгаа хийгдэж байна.	40

	2	Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах, мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг боловсруулах, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгох	2016-2020	УУХҮЯ	Батлагдсан - 327.8 Гүйцэтгэл - 136.0 Санхүүжилт - 103.1	Төслүүдийн үр дүнгийн тайланг хүлээн авч, санг баяжуулах	Геомэдээллийн сан-2017 төслийн 2017 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2017 оны А/46 болон А/96 дугаар тушаалаар баталсан. Төслийн 2017 оны ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголын материалтай танилцаж ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн. Төслийн үр дүнг 3-р улиралд хүлээн авна. "Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам"-ын төслийг боловсруулан Захиргааны ерөнхий хуулийн дагуу нөлөөллийн шинжилгээг хийж журмын төслийг боловсруулсан. Журмын төсөлд олон нийтийн хэлэлцүүлгийг яам, агентлаг, их сургуулиуд, хүрээлэн, мэргэжлийн холбоод, Канад Улсын олборлох салбарын СЕСМИМ төсөл, Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр АМЕП төслийн төлөөлөл бүхий 60 гаруй мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан. Яам, агентлагийн цахим хуудаст байршуулан санал авч байна. Архивын ерөнхий газар, Үндэсний дата төв, Ус, цаг уур орчны судалгааны хүрээлэнгээс холбогдох саналыг авч тусгасан.	40
2.61. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.	1	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	2017-2018	УУХҮЯ	-	Хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу "Ашигт малтмалын тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан тандан судалгаа хийж, оролцогч талуудын саналыг тусгах ажил хийгдэж байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохицуулах тухай саналыг Уул уурхайн тухай хуулийн төсөлд тусгаж "Газрын хэвлийн тухай" хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар судалгаа хийгдэж байна.	40
	4	Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2016-2020	УУХҮЯ		Бэлэн болсон 20-иос доошгүй уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах	2017 онд уурхай, уулын үйлдвэрийг улсын комисс хүлээлгэж өгөх нийт 46 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлснээс бичиг баримтын бүрдэл хангасан 7 уурхайг хүлээн авав. Бусад аж ахуйн нэгжүүдийн бичиг баримтын бүрдлийг хангуулах ажил хийгдэж байна.	70
	5	Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын төслийг хэрэгжүүлэх, үр дүнгийн тайланг хүлээн авах	2017-2020	УУХҮЯ	Төсөвгүй. Батлагдсан - 142.4 Гүйцэтгэл - 123.1 Санхүүжилт - 44.2	Улсын төсөв 950.0 Хамтран хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг хүлээн авах	БНЧех Улсын геологийн албатай хамтран геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн "Монгол Алтай-50" төслийг хэрэгжүүлж үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн УУХҮС-ын 2017 оны А/02 дугаар тушаалаар хүлээн авсан. -МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан "Хойт, төв, зүүн Азийн геологийн гүний процесс ба металлогени" төслийн 2017 оны суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/96 дугаар тушаалаар баталсан. Төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.	70
	6	Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гадаад орнуудаас ирүүлсэн саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017-2020	УУХҮЯ		Улсын төсөв 5,000.0 Гадаад орнуудаас ирүүлсэн хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг судалж, шийдвэрлэх	ОХУ болон МУ-ын ЗГ-ын хоорондын ээлжит хуралдаанаар ОХУ-аас тайлан хүлээн авах, хилийн бүсэд геологийн судалгааны ажлыг хамтарч хийх, зарим нэг ашигт малтмалаар эрлийн судалгааг хамтарч хийхээр шийдвэрлэсэн. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Геологийн товчооноос Монгол орны өмнөд хэсэгт 1:50000-ны зураглал, ерөнхий эрлийн төсөл хэрэгжүүлэх саналыг судлан хариу хүргүүлсэн. Ирүүлсэн саналд геологийн судалгааны ажлын үр дүнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий талбайд эрэл, хайгуулын хийж хайгуулын тусгай зөвшөөрлийн давуу эрхтэйгээр авахаар тусгагдсан байсан тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу хамтран төсөл хэрэгжүүлэх боломжгүйг мэдэгдсэн.	40

2.62. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.	1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалгаа хийж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийг ил тод, нээлттэй түгээх аргачлалын санал боловсруулах	2017-2018	УУХҮЯ		Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээ хялбар, шуурхай болох, олон нийтэд ойлгомжтой болох	"Талбайн солбицлыг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд яамдуудаас саналыг авч нэгтгэн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж 37-р тогтоолоор батлуулсан. Сонгон шалгаруулалтын журмын дагуу сонгон шалгаруулалтыг явуулж байна. 2017 оны эхний хагас жилийн байдлаар 9 тусгай зөвшөөрөл олгосон ба улсын төсөвт 5.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицол тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг бэлтгэн 2017 оны 3 дугаар сар 29-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж 3Г-ын 2017 оны 106 дугаар тогтоол гарсан.Хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдлийг цахимаар олгох, бэлтгэл хангах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т холбогдох материалыг хүргүүлсэн.	70
2.63. Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.	1	"Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого"-ыг шинэчлэн боловсруулах	2016-2017	УУХҮЯ		Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсгийг байгуулж, "Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн боловсруулж, батлуулах	УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Б/101 тоот тушаалаар Монгол Улсын Их Хурлын 2011 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого"-ын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэх, цаашид газрын тосны салбарт баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. "Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого"-ын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэх ажил хийгдэж байна.	40
	3	Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	2016-2019	УУХҮЯ		Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийх	Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Мөн "Хөрөнгө оруулалтын тухай" хуульд газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдэд татварын тогтвортой орчинг бүрдүүлэх талаар санал боловсруулсан.	40
	4	Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх	2016-2020	УУХҮЯ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 4,000,000.0 Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, тухайн жилийн зорилтот түвшин хүртэл нэмэгдүүлэх	2017 онд Тосон-Уул XIX талбайд 210 сая, Тамсаг XXI талбайд 231 сая, БХГ-97 талбайд 11 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг гэрээлэгч компаниуд тус тус хийж, нийт 1,1 сая тонн газрын тос олборлож экспортлохоос 2017 оны эхний 5 сарын байдлаар 403 мянган тонн газрын тос олборлож, экспортлон 67,5 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт оруулж, төлөвлөгөөний гүйцэтгэл 37 %-тай байна. Зорилтын хүрээнд "Газрын тосны тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан "Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага" журмыг боловсруулан бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.	70
						Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 3,500,000.0	УУЯ /хуучин нэрээр/-ны ТНБД-ын 81 дүгээр тушаалаар Ажлын хэсэг томилж Тамсаг XXI талбайн олборлолт нэмэгдүүлэх цооногийн байгууламж, тосны 208 цооног, усны 78 цооног, 7000м3-ын 3 сав, үний ус цэвэршүүлэх станц, бохир ус цэвэршүүлэх станц, ус тос ялгах байгууламж болон холбогдох	

5	Газрын тосны ордын дэд бүтэц, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх	2016-2020	УУХҮЯ	Тухайн жилийн зорилтот түвшинд хүрэх	барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст 2016 оны 6 дугаар сард ажиллаж, байгууламжийг хүлээн авсан. Мөн УУХҮЯ-ны ТНБД-ын Б/55 дугаар тушаалаар Ажлын хэсэг томилж Тосон-Уул XIX талбайн олборлолт нэмэгдүүлэх зооногийн байгууламж (2013 оны тосны 155 цооног, усны 29 цооног, ТА19-91 үйлдвэрлэлийн хяналтын ерөөний инженерчлэл, ТА1-11 шинээр барих тос буулгах байгууламж, 1-9 тос дамжуулах станцын өргөтгөлийн байгууламжуудыг 2016 оны 10 дугаар сард хүлээн авсан. Мөн Тамсаг XXI талбайн олборлолтын үйл ажиллагаанд эрчим хүчний найдвартай нөөц эх үүсвэрээр хангах хүрээнд БНХАУ-аас эрчим хүчний шугам татах талаар судалгаа хийсэн бөгөөд холбогдох зөвшөөрлийг авахаар Эрчим хүчний яаманд албан тоот хүргүүлээд байна.	70
6	Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлж, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх	2016-2020	УУХҮЯ	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 8,000.0	Зорилтын хүрээнд "Газрын тосны тухай" хуульд заасан "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам"-ыг боловсруулж БОНХАЖ-ийн сайдын /хуучин нэрээр/ зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Журмын төслийг Хууль зүйн /хуучнаар/ яаманд бүртгүүлэхээр хүргүүлсэн.	40
				Тухайн жилд хийхээр төлөвлөсөн байгаль орчин хамгаалах ажлыг хийх, хууль, журмыг мөрдүүлж хэвшүүлэх		
7	Газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх	2016-2020	УУХҮЯ	Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэтэй уялдуулан газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлэлцээрүүдэд оролцож, үнэ болон худалдааны нөхцөлийг сайжруулах	Доншен газрын тос /Монгол/ ХХК болон UNIPES компани хоорондын түүхий тосны худалдааны гэрээний үнэ, борлуулалт, тээвэрлэлтийн өртөгийн асуудлаарх хэлэлцээрийг 2016 оны 01 дүгээр сард зохион байгуулж, гэрээг сунгасан.	70
8	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж буй газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж, шинээр газрын тосны орд илрүүлэх	2016-2020	УУХҮЯ	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 300,000.0	Газрын тосны "Дарьганга-XXIV" талбайд ГТГ /хуучин нэрээр/ болон "Апекспро инвестмент лимитэд" ХХК-ийн хооронд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг "Монголиа Шин Ий Энержи" ХХК-д шилжүүлэх тухай асуудлыг Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. /ЗГ-ын 41 дүгээр тогтоол/ Газрын тосны хайгуулын "Ар булаг-XXIX" талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах эрх олгох асуудлыг Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. /ЗГ-ын 337 дугаар тогтоол/ Газрын тосны хайгуулын "Тариач-ХV" талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах эрх олгох асуудлыг Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. /ЗГ-ын 431 тоот тогтоол/ Газрын тосны "Эргэл-ХII" талбайд АМГТГ болон "Smart oil investment LTD" компанийн хооронд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2016 оны 08 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. /ЗГ-ын 53 дугаар тогтоол/ Газрын тосны хайгуулын "Богд-IV", "Онги-V" талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг буцаан шилжүүлэх асуудлыг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. /ЗГ-ын 181 тоот тогтоол/	70
				Газрын тосны хайгуул, үнэлгээний ажил эрчимжиж, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэх		
				Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 20,000.0	Газрын тосны 25 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаагаас 2016 онд Эргэл XII, Арбулаг XXIX талбайд БХГ-г гэрээг шинээр байгуулсан. Мөн нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3, газрын тосны 10, нийт 18	

	9	Газрын тос болон уламжлалт бус газрын тосны хуримтлал байж болох газарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх	2016-2020	УУХҮЯ	Эрэл, хайгуул, үнэлгээний ажлыг эрчимжүүлж, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэх	талбайд эрлийн гэрээ байгуулан, хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Газрын тосны хайгуулын Номгон-IX талбайд Австрали улсын хөрөнгө оруулалттай "Голден хорд лимитэд" ХХК-тай нүүрсний давхаргын метан хийн хайгуулын үйл ажиллагаа явуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахаар хэлэлцээрийг хийж, гэрээний үндсэн нөхцөлүүдийг тохиролцон холбогдох яамдуудаас санал авч байна.	70
	10	Хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр газрын тосны олборлолтоос гарч байгаа газрын тосны ууссан хийг ашиглах чиглэлээр судалгаа хийх, ашиглах	2016-2018	УУХҮЯ	Гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 200.0 Ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх	"МонСино Петролеум инженеринг" ХХК –иас "Тосон–Уул XIX" талбайд газрын тос олборлох явцад технологийн горимоор ялгарсан ууссан хийг боловсруулж CNG /Compressed natural gas/ гарган авах мөн тосонд ууссан хийг цэвэршүүлж цахилгаан үүсгүүрт ашиглах талаар ирүүлсэн төсөл, "Петрочайна Дачин Тамсаг" ХХК –иас ирүүлсэн, тосонд ууссан хийг цахилгаан үүсгүүрт хувирган ашиглах зөвшөөрөл хүссэн саналуудыг судлаж, дэмжин ажиллах талаар хариуг хүргүүлсэн.	40
	11	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй талбайд ой хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зурвас бүсийг байгуулах	2016-2020	УУХҮЯ	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 400.0 Зурвас байгуулах ажлыг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт нь суулгуулах, хэрэгжүүлж хэвшүүлэх	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй талбайд ой хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд зурвас бүсийг хэсэгчлэн байгуулж ажиллах талаар "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-д зөвлөсний дагуу тус компани ашиглалтын талбайд хамгаалалтыг бүс байгуулан ажиллаж байна.	40
	12	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга"-д хамруулах	2016-2020	УУХҮЯ	Улсын төсөв 10.0 Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийг уг хөтөлбөрт хамруулан, тайланг жил бүр хүргүүлдэг болох	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдээс "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга"-д хамрагдсан талаарх судалгааг явуулж байна. Мөн гэрээлэгч компаниудыг "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга"-д хамруулах талаар зөвлөмж өгч ажилласнаар "Петрочайна Дачин Тамсаг" ХХК, "Петро Матад" ХХК, "Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед" ХХК-иуд уг санаачлагад хамрагдаад байна.	40
2.64. "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	1	"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн боловсруулах	2016-2017	УУХҮЯ	- Журмыг батлуулан хэрэгжүүлэх	Сайдын 2017 оны А/15 тоот тушаалаар "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, журмыг төслийг шинэчлэн боловсруулж, 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн баталсан.	100
	2	Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг зохион байгуулах	2016-2020	УУХҮЯ	- Нэгдсэн зохион байгуулалтад оруулах судалгаа хийх	Бусад холбогдох байгууллагатай хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллахаар төлөвлөж байна. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-аар хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг хуулийн хүрээнд ажиллах нөхцлийг бүрдүүлж өгсөн.	40

2.65. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.	1	Уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах	2017	УУХҮЯ	- Төлөвлөлтийн баримт бичиг боловсруулж дуусгах	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хангах зорилгоор холбогдох яам болох Эрчим хүчний яам, Зам тээвэр, хөгжлийн яамны төлөөлөлтэй 2017 оны 1 улиралд уулзалт зохион байгуулж санал солилцон холбогдох мэдээллийг солилцов. Мөн төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулж төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах судалгааны ажил хийгдэж байна. Төлөвлөлтийн баримт бичгийн төслийг 4-р улиралд багтаан боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна.	40
	2	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах	2016-2020	УУХҮЯ	- Дэд бүтцийн хөгжлийн талаар хамтран ажиллах механизм бүрдүүлэх	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэх бичиг баримт боловсрогдоогүй байна.	/-/
2.66. Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно.	1	Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулах	2017	УУХҮЯ	- Санал боловсруулах	Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулах чиглэлээр шаардлагатай мэдээллийг цуглуулан боловсруулж байгаа бөгөөд судалгааны нэгж байгуулах саналыг 2017 оны 4-р улиралд багтаан боловсруулан танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.	/-/
	2	Уул уурхайн судалгааны нэгж байгуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх	2017	УУХҮЯ	- Нэгж байгуулагдах асуудлыг шийдвэрлүүлэх	Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулах чиглэлээр шаардлагатай мэдээллийг цуглуулан боловсруулж байгаа бөгөөд судалгааны нэгж байгуулах саналыг 2017 оны 4-р улиралд багтаан боловсруулан танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.	/-/
2.67. Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.	1	Тухайн үйлдвэрийн технологиор ашиглах боломжгүй овоолго, хаягдлын аж ахуйг эргүүлэн ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх	2017	УУХҮЯ	- Эрх зүйн орчин бүрдэх	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн УИХ-аар хэлэлцэн батлагдсантай холбоотойгоор "Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам" болон "Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Журам батлах тухай" Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор батлуулсан ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 дугаар тушаалаар журмын хэрэгжилтийг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.	100
	2	Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх	2017-2018	УУХҮЯ	- Журмын төсөл боловсруулах	"Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын төслийг боловсруулах Дэд ажлын хэсгийг УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ болон судлаачдын бүрэлдэхүүнтэй байгуулав. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийж, вэб сайтад төслийг байршуулан олон нийтийн саналыг авч байна. Журмын төсөлд санал авахаар БОАЖЯ-нд 05 дугаар сарын 22-ны өдөр 01/1166 албан тоотой хүргүүлээд байна.	70
2.68. "Алт-2"					-	Алтын санхүүжилтийн асуудлаар Сангийн яам, Монголбанкны салбар	

хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанктай хамтран шийдвэрлэнэ.	1	"Алт-2" хөтөлбөрийн санхүүжилтийн тооцоог гаргах	2017	УУХҮЯ		Судалгаа хийж, тооцоог гаргах	зөвлөлийн холбогдох хүмүүс, алт олоорлогч томоохон 25 аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулсан уулзалтыг УУХҮЯ дээр зохион байгуулсан. Санхүүжилт шаардлагатай алтны 130 төслийн судалгааг гаргаж Хөгжлийн банкинд хүргүүлсэн.	70
	2	Санхүүжилтийн тооцоог Монголбанкинд хүргүүлж шийдвэрлүүлэх	2016-2017	Монгол банк		Гадаад зээл 250,000.0 Санхүүжилт шийдвэрлэгдэх	ОУВС-тай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн үндсэнд Монголбанкнаас алтны санхүүжилтийн эх үүсвэрийг гаргах боломжгүй болсон. Хөгжлийн банк зээллэг хүссэн 13 ААН-ийг судалж, материалаа бүрэн бүрдүүлж шаардлага хангасан алт олборлогч 3 ААН-д 21,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоод байна.	70
2.69. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	1	"Алт-2" хөтөлбөрийг боловсруулан батлуулах	2016-2017	УУХҮЯ		- Хөтөлбөр батлагдах	СЯ, БОАЖЯ, Монголбанктай хамтарсан ажлын хэсэг байгуулан Алт-2 үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулан Засгийн газрын 2017 оны 1-р сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 20-р тогтоолоор батлуулсан.	100
	2	Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах	2017-2018	УУХҮЯ		- Хууль, эрх зүйн орчныг боловронгуй болгох чиглэлээр судалгаа хийх	"Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ерөнхий сайдын 2017 оны 17-р захирамжаар хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлагнах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөл байгуулсан. Зөвлөлийн бүрэлдэхүүнд 4 дэд салбар холбогдох хууль эрх орчинг боловсронгуй болгохоор төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан эрх зүйн баримт бичгүүдэд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийн судалгааг хийж байна.	40
	3	Алтны геологийн судалгаа, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлыг хэмжээг өсгөн нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх	2017-2018	УУХҮЯ	Батлагдсан - 1740.0	Улсын төсөв 2,000.0 Алтны хэтийн төлвийг үнэлэх чиглэлээр эрэл-үнэлгээний ажлыг эхлүүлэх	"Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Монгол орны төв, зүүн бүсийн алтны хэтийн төлвийг үнэлэх эрэл-үнэлгээний сэдэвчилсэн судалгааны ажлын геологийн даалгаврыг боловсруулан ТНБД-аар тушаалаар баталсан. Төслийн 2017 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/46 болон А/96 дугаар тушаалаар баталж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Алтны ордын 17 хайгуулын ажлын үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /ЭБМЗ/-ийн хуралдаанаар хэлэлцэн улсын нөөцийн санг 3312 кг нөөцөөр нэмэгдүүлээд байна.	70
	4	Сорьцын хяналтын албаны чадавхийг бэхжүүлж, техник технологийг шинэчлэх	2016-2017	СЯ		Улсын төсөв 1,200.0 Хүчин чадлыг нэмэгдүүлж, техник технологийг шинэчлэх	Швейцарийн Хөгжлийн Агентлаг /ШХА/-ийн "Тогтвортой бичил уурхай" төслөөс 2016 онд 6 кг хүртэлх жинтэй алт хайлах зуух 1 ширхэгийг дагалдах тоног төхөөрөмжийн хамт Сорьцын хяналтын газарт худалдан авч өгсөн бөгөөд одоогийн байдлаар гааль дээр хүлээгдэж байна. Нийтдээ 40,0 сая орчим төгрөг зарцуулсан байна. Төслийн зүгээс 2017 онд аналитик жин 2 ширхэгийг, үнэт металлын сорьц тогтоох XRF машин 1 ширхэгийг нийт 80.0 сая орчим төгрөгөөр авч өгөхөөр төлөвлөсөн байна.	40
						Гадаад зээл 2,000.0	Монголбанкны Ерөнхийлөгч болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/62, А/98 хамтарсан тушаалаар Алт үйлдвэрлэх үндэсний үйлдвэр банк	

	5	Алтыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулах	2017	СЯ		Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх	байгуулах талаар судалгаа хийж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Монголбанк, Швейцарь улсын ARGOR-HERAEUS S.A. компанийн төлөөлөлтэй Алт цэвэршүүлэх үйлдвэрийн суурь судалгааг хийлгэх асуудлаар уулзалт зохион байгуулж, тус судалгааны тайланг Монголбанкны захиалгаар ARGOR-HERAEUS S.A.компани боловсруулахаар тохиролцож, эдгээр байгууллагуудын хооронд хамтран ажиллах гэрээ хийгдсэн байна.	40
	6	Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	УУХҮЯ		Алтны олборлолтын хэмжээ нэмэгдэх	2016 онд 15 алтны уурхай, 2017 онд 7 уурхайд комисс ажиллан ашиглалтанд хүлээн аваад байна.	40
	7	Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалж хэрэгжүүлэх	2016-2019	УУХҮЯ		Холбогдох байгууллагуудтай хамтран нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судлагаа хийх	Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалгаа хийгдэж байна.	40
	8	"Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх	2017	УУХҮЯ		Журмын төслийг боловсруулж батлуулах	"Алт агуулсан хүдэр, элс олборлон баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай холбогдсон журам"-ын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, хуульд заасны дагуу Нөлөөллийн шинжилгээ хийсэн. Журмын төслийг яамны веб сайтад байршуулан олон нийтийн санал, зөвлөмжийг авч, улмаар СЯ, СХЗГ, ЦЕГ, Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооноос санал авч тусгасан. Мөн алтны чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, уулзалтын үеэр алтны салбарт тулгамдаад байгаа асуудал, тэдгээрийг шийдвэрлэх нөхцөл боломжийн талаар санал солилцон шинээр боловсруулсан журмын төслийг танилцуулан хэлэлцүүлэг хийж тэдгээрээс гарсан саналыг журмын төсөлд тусгаад байна.	70
2.70. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.	1	Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэгж байгуулах, үйлдвэрийн дэд бүтцийн нарийвчилсан судалгаа, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэх	2016-2017	УУХҮЯ		Төслийн нэгж байгуулагдах, үйлдвэрийн дэд бүтцийн судалгаа хийгдэх	Засгийн 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 92 дугаар тогтоолоор Төсөл хэрэгжүүлэх Төрийн өмчит компани байгуулагдсан. УУХУСайдын 2017 оны А/26 дугаар тушаалаар Монгол улсын Засгийн газар болон БНЭУ-ын Экспорт-Импорт банк хооронд байгуулсан зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн нарийвчилсан техник,эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажлын даалгаврыг монгол, англи хэл дээр боловсруулж баталсан.	100
	2	Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангах	2017	УУХҮЯ		Улсын төсөв 516.0 Санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн талаар холбогдох шийдвэрийг гаргуулах	Түүнчлэн Сангийн яамтай хамтран Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж ЗГ-ын 2017.2.17 өдрийн хуралдаанаар "Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн тухай" 59 дүгээр тоот тогтоолыг батлуулсан. Уг тогтоолоор Монгол улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импорт банк хоорондын 1,0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийг хэрэгжүүлэхээр тогтсон. Монгол улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импорт банк хооронд 2016 онд байгуулсан зээлийн хэлэлцээрийн зориулалтыг өөрчлөх асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодор хэлэлцүүлж дэмжүүлэн, УИХ-ын чуулганы 5 сарын 31-ний өдрийн хуралдаанаар зээлийн хэлэлцээрийг соёрхон батлуулсан.	100

	3	Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, барилгын зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх	2017	УУХҮЯ		Нарийвчилсан ТЭЗҮ, барилгын ажлын зураг төсөл хийгдэх	УУХҮЯамны ТНБД-ын 2017 оны А/16 тоот тушаалаар "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх компанийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хороо төслийн зөвлөх компанийг сонгон шалгаруулсан бөгөөд тус компанитай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулахаар хэлэлцээр хийж байна.	40
	4	Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах	2017-2020	УУХҮЯ		Гадаад зээл 2,400,000.0 Үйлдвэр барих ажил эхлэх	Хугацаа болоогүй.	/-/
2.71. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.	1	Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах	2016-2017	УУХҮЯ		- Хуулийн этгээдийг сонгон шалгаруулах	УУХҮ-ийн Сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн төслийн нэгжийн захирал томилогдсон. 2017 оны 01 дүгээр сард төслийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн дарга баталсан. 2017 оны Төсвийн тодотгоолоор үйл ажиллагааны төсөв нь батлагдан хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Засгийн газрын 2017 оны 03 дүгээр сарын 15-ны өдрийн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоолоор үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүйгээр эзэмшихээр шийдвэрлэсэн. Тус үйлдвэрт хөрөнгө оруулалт татах чиглэлээр БНХАУ-ын "Чайналко" ХХК-тай хамтран ажиллаж байна.	70
	2	Үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн ажлыг хийх	2016-2017	УУХҮЯ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 4,400.0 Үйлдвэрийн зураг, төсөл хийгдэх	Хугацаа болоогүй. Ажил 2017 оны 2-р хагасаас эхэлнэ.	/-/
	3	Үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах	2017-2020	УУХҮЯ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1,756,480.0 Үйлдвэр барих ажил эхлэх	Хугацаа болоогүй.	/-/
2.72. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.	1	Дархан-Сэлэнгийн бүсэд байгуулах хар төмөрлөгийн цогцолбор төслийн ТЭЗҮ болон БОННУ-г боловсруулах ажлыг гүйцэтгэж дуусгах	2016-2017	УУХҮЯ		ТЭЗҮ болон БОННУ-г хүлээн авах	"Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн ТЭЗҮ болон БОННУ-ний дунд шатны тайлангуудыг хянаж, хүлээн авсан. Цаашид гүйцэтгэх банкны ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай санал, зөвлөмжийг тус төслийн ТЭЗҮ-г боловсруулж байгаа Канад Улсын "Hatch" компанид хүргүүлсэн. Эцсийн тайланг 2017 оны 9 дүгээр сард хүлээж авахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн уг ТЭЗҮ-ийн урьдчилсан тайланд Дэлхийн банкаар эксперт хийлгэх сэдэв, бүлгийг сонгон дэлхийн банкны Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл /УУДБХОДТ/-д хүргүүлсэн.	70
	2	Давтах аргаар ган бөмбөлөг үйлдвэрлэх цехийг ашиглалтад оруулах	2016-2017	УУХҮЯ		Үйлдвэр ашиглалтад орох	"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь давтах аргын ган бөмбөлгийн үйлдвэрийг 2017 оны 01 сарын 28-нд ашиглалтад оруулсан. Үйлдвэрийн нээлтийн ажиллагаанд яам, агентлагийн төлөөлөл оролцов.	100
	3	Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулах	2017-2018	УУХҮЯ		Үйлдвэрийн барилгын ажил явагдах	Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх төлөвлөгөө "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан ба тоног төхөөрөмжийн үнийн судалгаа, хөрөнгө оруулалтын арга замуудыг судалж байна.	40

	6	Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах	2017-2020	БХБЯ		Төр, хувийн хэвшлийн түншлэл 200,000.0 Төмөрлөгийн үйлдвэрлэлийг дэмжиж, гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төмрийн хүдэр, баяжмал экспортлох төмөр замын тээврийн тарифыг уян хатан болгох асуудлаар “Улаанбаатар төмөр зам” ХНН, болон Төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбооны төлөөллийг оролцуулан УУХҮ-ийн Сайдтай уулзалт зохион байгуулав.	40
2.73. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.	1	Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн нэгж байгуулах	2016-2017	УУХҮЯ		Төслийн нэгж байгуулагдах, холбогдох судалгаа хийгдэх	Засгийн газраас 2016 онд баталсан 107 дугаар тогтоолоор “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” барих төслийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулахаар шийдвэрлэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/43 дугаар тушаалаар Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн нэгжийг байгуулан ажиллаж байгаа ба Төслийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. 2017 оны Төсвийн тодотголоор үйл ажиллагааны төсөв нь батлагдан ажиллаж байна.	100
	2	Дэлхийн банкны санхүүжилтээр боловсруулагдсан нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг хүлээж авах		УУХҮЯ		Урьдчилсан ТЭЗҮ-ийг хүлээн авах	“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр холбогдох мэргэжлийн хүмүүсээр хэлэлцүүлэн хүлээн авсан.	100
	3	Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ болон БОННУ-г Хүнд үйлдвэрийн шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх	2017	УУХҮЯ		Улсын төсөв 318.0 Нарийвчилсан ТЭЗҮ, БОННУ-ний тайланг хүлээж авах	“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2017 оны 05 сарын 4-ний өдөр УУХҮЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан.	100
	4	Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангах		УУХҮЯ		Санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн талаар холбогдох шийдвэрийг гаргуулах	Монгол Улсын ерөнхий сайдын 113-р тоот захирамжаар байгуулагдсан “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдааны 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Ажлын хэсэг холбогдох судалгааны ажлыг хийж байна.	40
2.74. Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.	1	Улаанбаатар хотод жилд 15,000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжих	2016-2019	УУХҮЯ		- Үйлдвэр барих ажил эхлэх	Төсөл хэрэгжүүлэгч “Интер стандарт нефть” ХХК нь ХБНГУ-ын “EDL Anlagenbau” компаниар үйлдвэрийн ТЭЗҮ-г гүйцэтгүүлж дуусан 2016 оны 04 дүгээр сард Аж үйлдвэрийн яамны /хуучнаар/ ШУТЗ-өөр үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцүүлэн дэмжүүлсэн. Төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 43 сая ам.доллар бөгөөд үнээс “Интер стандарт нефть” ХХК нь өөрийн хөрөнгөөр төслийн нийт хөрөнгө оруулалтын 20%-г, 60%-г Германы “HypoVereinsbank”-ны зээлийн эх үүсвэрээр үлдсэн 20%-ийн МУ-ын Хөжлийн банкны хөнгөлттэй зээлийн эх үүсвэрээр тус тус санхүүжүүлэхээр тохиролцож шаардлагатай бичиг баримтыг хүргүүлээд байна.	40
2.75. Метал хийц,		Автомашин, хөдөө аж ахуйн				-	Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, машин механизм угсрах,	

угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ.	1	тоног төхөөрөмж, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулахыг дэмжих	2017-2020	УУХҮЯ		Үйлдвэр, технологийн парк байгуулах судалгааны ажлууд хийгдэх	автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд ШУТИС-ын механик, тээврийн сургууль болон Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлтэй хамтран судалгааны ажлыг эхлүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд Азийн орнуудын автомашины эд анги үйлдвэрлэх паркийн туршлагын талаар судалж байна. Мөн Монгол улсын хувьд машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк	40
	2	Ачааны автомашин, нийтийн тээвэр, хөдөө, аж ахуйн машин, механизмыг угсрах үйлдвэрлэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2016-2017	УУХҮЯ		Эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Автомашин, нийтийн тээвэр, хөдөө, аж ахуйн машин, механизмыг угсрахад зориулагдсан тоног төхөөрөмжийг импортлоход НӨАТ, Гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулсан бөгөөд Сангийн Яамнаас уг асуудлыг Засгийн газарт болон УИХ-д оруулж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.	70
2.92. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.	2	Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх	2016-2018	БХБЯ		Судалгаа хийж, төсөл боловсруулах	ШУТИС-ын дэргэдэх Усны судалгааны төвөөс Хөрсний усыг үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах, энэ чиглэлээр судалгаа хийхэд шаардагдах төсөв, хөрсний усыг ашиглах төслийн саналыг үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ-нд ирүүлсэн ба асуудлыг судалж байна.	/-/
2.106. Метан хийг ашиглах боломжит нөөцийг бүрдүүлэх судалгааг эрчимжүүлэх, хийн хангамжийг хөгжүүлэх эрх зүй, дэд бүтцийн орчныг бүрдүүлэх, нүүрснээс хийн цэвэр түлш гарган авах үйлдвэр барих төслийг эхлүүлнэ.	1	Метан хийн нөөцийг бүрдүүлэх болон салбарын хөгжлийг дэмжсэн бүтэц зохион байгуулалтыг бий болгох	2016-2017	ЭХЯ		Холбогдох шийдвэрүүд гарах	Метан хийн хангамжийн салбарын зохион байгуулалтын бүтцийг MNS 6659-2017 стандартаар тодорхойлон батлуулж, эрх зүйн орчинг бүрдүүлээд байна.	/-/
Тэргүүлэх зорилт №3.2.2. Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.								
3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.	11	Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн дотоод зураг төсөл, үзүүлэн бэлтгэх, макет, үзвэрүүдийг хийх, тохижилт болон бусад арга хэмжээг зохион байгуулах	2017	ЦЭКАА		Байгууламжийн дотоод зураг төсөл, үзүүлэнг бэлтгэх	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас хийгдсэн ажил байхгүй байна.	/-/
Тэргүүлэх зорилт №4.1. Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.								

4.1.3. Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.	1	Байгаль орчны үнэлгээ, аудитаар дамжуулан ашиглагч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх	2016-2020	БОАЖЯ	200-250 төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна.	/-/
4.1.6. Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.	1	Цэвэр агаар санг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах	2016-2020	БОАЖЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд	Агаарын чанарыг сайжруулах бүсийг цэвэр түлшээр хангах, эрчим хүч, дулааны алдагдлыг бууруулах, өндөр үр ашигтай халаалтын технологи нэвтрүүлэхийг дэмжих	Улаанбаатар хот болон томоохон суурин газруудад 2017 оноос шатахууны чанарыг Евро-5 стандартад шилжүүлэхээр төлөвлөсөн ажлын хүрээнд автобензин, дизель түлшний Евро-5 стандартын жишигт нийцсэн Үндэсний стандартын төсөл боловсруулан Стандартчиллын Үндэсний хорооны 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Роснефть компанитай Евро-5 стандартын шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, импортын үнийн хөнгөлөлт үзүүлэх талаар уулзалт хэлэлцээр хийж тодорхой асуудлуудаар тохиролцоонд хүрээд байна.	/-/
4.2.3. Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.	2	Ус ашиглалтыг бүрэн тоолууржуулж, хаягдал бохир усыг цэвэрлэж, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	2017-2020	БОАЖЯ	Усны тоолууртай ус ашиглагчийн тоо болон ус эргүүлэн ашиглалт, дахин ашиглалтыг дэмжиж нэмэгдүүлэх	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна.	/-/
4.2.6. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ.	1	Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, нөхөн сэргээлт хийх	2016-2020	БОАЖЯ	Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх хуулийн төсөл боловсруулах	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна.	/-/
	3	Аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, чадавхийг бэхжүүлэх замаар нөхөн сэргээлтийн ажлын чанар үр дүнг дээшлүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	2017-2020	БОАЖЯ, МХЕГ	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААН, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, нутгийн иргэдийн оролцоотойгоор 300-аас доошгүй га талбайд нөхөн сэргээлт хийх	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна.	/-/
	4	Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр хэрэгжүүлж, холбогдох стандартуудыг шинэчлэх, сургалт, судалгааны төв байгуулах	2016-2020	БОАЖЯ	Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөрийн төсөл боловсруулж, сургалт судалгааны төвийн барилгын ажлыг эхлүүлэх	БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар БНСУ-ын Уул уурхайн Нөхөн Сэргээлтийн Корпораци (MIRECO) болон Монгол Улсын БОАЖЯ хамтран хэрэгжүүлж буй "Монгол улсад Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн чадавхийг бэхжүүлэх" төслийн Мастер төлөвлөгөө боловсруулах багт яамны төлөөлөл ажиллаж байна. Холбогдох сургалтад хамрагдсан.	40

5	Орхон, Туул гол болон бусад голуудын хамгаалалтын бүсэд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах, хариуцлагатай уул уурхайн зарчмыг мөрдүүлж усны бохирдлыг бууруулах	2016-2019	БОАЖЯ		Орхон, Туул болон бусад томоохон голуудыг бохирдуулж буй үйл ажиллагааг зохицуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	Холбогдох хууль, тогтоомжийн дагуу ажиллаж байна.	/-/
6	Баруун бүсэд дүйцүүлэн хамгааллын жишиг төсөл хэрэгжүүлэх	2016-2019	БОАЖЯ		Баян-Айраг, Хотгор, Хөшөөтийн орд газрын биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийг боловсруулах	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас Даян дэлхийн байгаль хамгаалах сан /GEF/ НҮБХХ-ийн буцалтгүй тусламжтайгаар нийт 1,289,863 ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Монгол орны баруун бүсэд хөгжлийн сөрөг нөлөөлөл, газрын доройтлыг бууруулах үе шат, дүйцүүлэн хамгааллыг ландшафтын түвшний төлөвлөлт, менежментэд нэвтрүүлэх замаар уул уурхайгаас бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой "Монгол орны баруун бүс нутгийн газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх" төслийн Удирдах хороонд яамны төлөөлөл ажиллаж байна. Удирдах хорооны 2 дугаар хуралдаанд оролцсон. Төслийн хагас жилийн тайлантай танилцаж, санал хүргүүлсэн.	40

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

